



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 12 -ны өдөр

Дугаар А/20

Эрдэнэт

Тусгай зөвшөөрөл сунгах, хаягийн шилжилт
хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3, 19.17, 19.18, 19.20, Зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1, 2.4, 6 дугаар зүйлийн 1.3 1 дэх заалтууд, Аймгийн Засаг даргын 2022 оны А/764 дүгээр захирамж, ЭМС-ын 2021 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/400 дүгээр тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын дэргэдэх "Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс"-ын 2023 оны 03 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дугаар хурлын шийдвэрийн дагуу эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах байгууллагын нэрсийг нэгдүгээр, хаягийн шилжилт хийх байгууллагыг хоёрдугаар, үйл ажиллагааг түдгэлзүүлэх байгууллагыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг "Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс"-ын гишүүдэд үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг УТХ-ийн Бодлого төлөвлөлт хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Уртнасан/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны
12 дүгээр сарын 12 ны өдрийн
№1 дугаар тушаалын I хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ
БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг, байршил	Хугацаа
1	"ЗБЗ амьдрал бэлэглэгч" ХХК-ын "Мөнхийн үйлс" клиник	Уламжлалтын амбулаторийн хэвтүүлэн тусламж үйлчилгээ болон эмчлэх	Хүрэнбулаг баг, 4-р хороолол White house байранд	5 жил
2	Шигшмэл эрдэнэ ХХК-ын "Шигшмэл эрдэнэ" клиник	Нүүр ам судлалын тусламж үйлчилгээ	Уурхайчин баг 3-22-р байр 17 тоот	5 жил
3	Монос Орхон фарм ХХК-ын "Монос Орхон" 1-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах	Хүрэнбулаг баг, 4-р хороолол, Саруул төвийн нэг давхарт	5 жил
4	Ойгон өлзий ХХК-ын "Ойгон өлзий" 2-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах	Баянцагаан баг 206 байр	5 жил
5	Эмодин ХХК-ын "Эмодин" 1-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах	Зэст баг 1-р хороолол 3-р байр 58 тоот	5 жил
6	Мөнхийн тун ХХК-ын "Мөнхийн тун" 1-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах	Хүрэнбулаг баг -4-24 байр 01 тоот	5 жил

Эрүүл мэндийн газрын даргын 20223 оны
03 дүгээр сарын 18 ны өдрийн
4/... дугаар тушаалын II хавсралт



ХАЯГИЙН ШИЛЖИЛТ ХИЙХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хүчинтэй хугацаа
1	Мөнгөнжин Уул ХХК-ын Мөнгөнжин Уул 1-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах	Цагаанчулуут баг, 7а хороолол, 14-р байр, 103 тоотод шилжин байрших	2027.08.23

Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны
03 дүгээр сарын 13 ны өдрийн
1/10 дугаар тушаалын 3 хавсралт



ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг, байршил	Түдгэлзүүлэх хугацаа
1	НОМАМИ ХХК-ын НОМАМИ 2-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах	Оюут баг 5 дугаар байр 36 тоот	2023 оны 03-р сарын 09-нөөс 06-р сарын 09-ны өдрийг хүртэл